

## БАРУУН ХИЛИЙН ЗЭВСЭГТ ТУЛГАРАЛТ БА ХИЛИЙН СУМДЫН АРД ИРГЭД

### **Ш.Лхачинжав.**

Цэргийн ухааны доктор (Ph.D), профессор, хошууч генерал

### **Ц.Эрдэнээ.**

Хил судлалын хүрээлэнгийн судлаач, доктор (Ph.D), хурандаа

**Товч агуулга.** БНМАУ-ын 1930-1940 оны БНМАУ-ын гадаад, дотоод улс төрийн нөхцөл байдал, Шинжаантай хиллэх баруун хязгаарт болсон гадны зэвсэгт халдлага, байлдааны ажиллагаа, дээрэм тонуулын эсрэг тэмцсэн Орон нутгийн ард иргэдийн оролцооны талаар өгүүлэх болно.

**Түлхүүр үгс.** Улсын хил, нутаг дэвсгэрийн халдашгүй бүрэн бүтэн байдал, хилийн аюулгүй байдал, орон нутгийн ард иргэдийн оролцоо.

**Оршил.** Монгол орны баруун хязгаар 1930-1940 оод онд үймээн самуун, дээрэм тонуул, байлдаан тулааны талбар болоход нөлөөлсөн хүчин зүйлс нь нэг талаас манай улстай хил залгах ЗХУ, Хятадын болон Олон улсын цэрэг, улс төрийн төвөгтэй нөхцөл байдал, нөгөө талаас БНМАУ-ын төрийн эрх баригчдын бодлого, үйл ажиллагаа голлох нөлөө үзүүлжээ. Иймд баруун хязгаарын цэрэг, улс төрийн гадаад, дотоод нөхцөл, онцлог шинж чанарыг үнэлэн дүгнэх, Монгол Улсын төрөөс газар нутаг, хилийн халдашгүй дархан байдлын төлөө авч явуулсан арга хэмжээ, түүний үр дүн, сургамжийг тодорхойлох шаардлагатай юм.

**Үндсэн хэсэг.** Баруун хязгаарт үймээн самуун, дүрвэлт, дээрэм тонуул, байлдаан тулааны талбар болгоход нөлөөлсөн гадаад дотоод нөхцөл байдлыг авч үзье.

**Гадаад нөхцөл байдал.** Манай улсын баруун хязгаартай хил залгах Шинжаан мужийн ард олны доторхи ястан үндэстэн, шашин мөргөл, нутаг бэлчээрийн зөрчил

1930-аад оноос илт хурцдав. Үүнийг ашиглан тус мужийг Хятадын захиргаанд бүрэн оруулж, БНМАУ-ын баруун талаас нь довтолох, түшиц газар болгохыг Гоминданы хятадын эрх баригчид санаархаж байлаа.

Энэ үед хасгийн дээрэмчид Шинжаан мужийн зүүн өмнөд зах Бархөлөөс Алтайн нуруу хүртэлх орон зайд Монголын хилийн ойролцоо нутаглаж байв. Тэд Гоминданы хятадын нөлөөгөөр БНМАУ дахь казакуудыг урвуулан хүчээ бэхжүүлэхийг эрмэлзэж, манай нутагт цөмрөн довтолж, хүн ардыг хөнөөх, мал хөрөнгийг дээрэмдэн, газар орныг тагнах зэргээр хил дээр удаа дараа зэвсэгт мөргөлдөөн гаргаж, орон нутгийн энгийн номхон ард түмний амгалан тайван байдлыг алдагдуулж, баруун болон баруун өмнөд хязгаар, нутгийг түгшүүртэй болгож байсан юм.

**Дотоод нөхцөл байдал.** 1930-аад оноос эхлэн Монголын зүүнтэн хэмээн өөрийгөө зарласан хэсэг этгээдүүд Коминтерний нөлөөгөөр монголын угсаа язууртай хүмүүс, эрдэм номтой лам хуврагуудыг хөнөөж, сүм хийдийн

жасын малд татвар ногдуулж, сүм хийдийг нь шатаан устгаж, тайж ноёдын мал, хөрөнгийг хурааж, эх орондоо амар тайван амьдрах аргагүй болсон тул хил орчмын аймаг, сумын ардууд хил даван нүүж эхэлжээ. 1931 онд Өмнөговь аймгийн 2000 айлын 8000 иргэд хил даван дүрвэн нүүж, 1930-1932 онуудад нийтдээ 7500 өрхийн 30 000 хүн хил даван дүрвэжээ. 1933 онд Ховд, Баян-Өлгий аймгийн тал хувь нь, Говь-Алтай, Баянхонгор аймгийн тодорхой тооны айлууд хил даван нүүж, тухайлбал Шинжааны Ховогсайр руу Ховдын Булганаас нэг удаа гэхэд л 245 айлын 735 хүн хил даван нүүж байсан байна. Монголын хүн ам 1935 оны тооллогоор 738.2 мянган хүрч байсныг архивын материалд тусгасан байна.

Тухайлбал: 1933 он хүртэлх хугацаанд БНМАУ-ын баруун, баруун өмнөд талын аймгуудаас бүрэн бус тоогоор 9400-аад өрх айлын 37700 орчим хүн дүрвэн гарсан байна. **/хүснэгтээр харуулав/**

Архивын эх сурвалж, судалгааны баримтуудад тулгуурлан хасгийн болон Гоминданы Хятад, Оспаны зэвсэгт халдлагын эсрэг орон нутгийн ард иргэдийн тэмцлийг дараах үе шатуудад ангилан авч үзэж болохоор байна. Үүнд:

**Нэгдүгээр үе шат. (1933-1943)** Дүрвэх хөдөлгөөнийг таслан зогсоох, хасгийн зэвсэгт бүлэглэлийн эсрэг явуулсан зэвсэгт тэмцэл;

**Хоёрдугаар үе шат. (1944-1946)** БНМАУ-ын зүгээс Оспантай холбоо тогтоон, хэлэлцээр байгуулж, Орон нутгийн ард иргэдийг хилийн чанадад үүрэг гүйцэтгүүлж, дүрвэсэн иргэдээ татан авчрах;

**Гуравдугаар үе шат. (1947-1949)** Оспан 1946 оны дундуур ЗХУ, БНМАУ-аас холбоотныхоо харилцааг тасалж, Гоминданы хятадын талд урван орсноор манай улсын баруун хязгаарын нөхцөл байдал дахин хурцадсан үе болно.


Дүрвэх хөдөлгөөн хүрээгээ тэлж өргөжих болсонтой холбогдуулан төр засгаас тэдний дунд ухуулга яриа хийх, хилийн харуул, постыг шинээр байгуулах, хүн хүчээр бэхжүүлэх, гүйцэтгэх ажлын шугамаар дүрвэгсдийн дунд болон хилийн чанадад “маршрут нууц”, “суурин нууц” зэрэг ажиллагаануудыг явуулж, тэдгээрийн зорилго, чиглэлийг тодорхойлох, хүчийг нь задлан бутаргах, толгойлогчдыг нь устгах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж байсан.

Тухайлбал, Ховд аймгийн Булган сумын харьяат ард Б.Дүгэр, Б.Уртнасан, Б.Сахаан, С.Чой нарын идэвхтэй үйл ажиллагааны үр дүнд “...1932 онд 1807 айл өрхийн 6951 хүн, 1933 онд 1148 айл өрхийн 5230 гаруй иргэдийг эх оронд нь буцаан авчирсан байна.” Мөн Б.Дүгэр, Б.Уртнасан, Б.Сахаан нарыг давхардсан тоогоор 14 удаа дээрэмчдийн үүрлэн суурьшсан чиглэлд илгээж, дээрэмчдийн зорилго, үйл ажиллагаа, байрлал, хүч хэрэгслийн талаарх мэдээллийг олзворлон авчээ. Тэдний мэдээнээс үзвэл: Чингэл, Цагаан голд 1600, Байтаг богд, Хавтагийн нуруугаар 700, Эрчис голын эхээр 300 гаруй өрх айл, төрөл бүрийн буу, зэвсгээр зэвсэглэсэн байна. Зэвсэгт бүлэглэлүүдэд морь унаж чадах хөгшин, залуу бүх эрчүүд цэрэглэн мордож байжээ. Тухайлбал: Ховдын хилийн отрядын даргаас “...манай

хариуцсан хилийн хэсгээр 1933 оны сүүлийн 4 сарын хугацаанд 1048 өрх айлын 5030 хүн, бод, бог мал 35000 гаруй Шинжаанаас нэвтрэн ирсэн”.

Үүнд 1932-1934 онд Монгол Улсад буцаж нүүн ирсэн айл өрхийн судалгааг графикаар харуулбал:

Зураг 1. 1932-1934 онд Монгол Улсад буцаж нүүн ирсэн айл өрхийн судалгаа



Эх сурвалж: Тагнуулын ерөнхий газрын тусгай архив.  
сх-4, д-3, хн-87, х-5-6.

Тухайн үед хилийн шугам, овоо тэмдэг тодорхойгүй, хязгаарын цэргийн анги, салбарууд дөнгөж байгуулагдсан тул цэрэгт татагдан ирсэн дайчид газар орны байдлаа гүйцэд судлан таниагүй зэрэг нөхцөл байдалтай байв. Уг нөхцөл байдлыг ашиглан Цагаан, Чингэл голуудын орчмоор зэвсэгт дээрэмчид хил нэвтрэн, ард олны амар амгалан байдлыг алдагдуулж байснаас гадна Байтаг Богд, Хавтагийн нуруунд буй хасаг, торгууд, урианхай, захчин нарыг дээрэм тонуулынхаа ажилд татан оролцуулж байлаа.

Алтайн комендатурын даргаас 1934 оны 8-12 дугаар сард “...1095 хүн 20 удаа хил зөрчин Алтай аймгийн Тамч, Цээл, Цогт, Эрдэнэ, Төгрөг, Баян-Өндөр сумдын ардуудын нийт 8848 толгой мал, 10-22 насны 11 охидуудыг дээрэмдсэн” хэмээн Дотоодыг хамгаалах газрын удирдлагадаа илтгэж байснаас үзэхэд хасгийн зэвсэгт бүлэглэлийн

үйл ажиллагаа нь БНМАУ-ын тусгаар тогтнол нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд шууд заналхийлсэн үйлдэл байжээ. Дээрэмчдийн өдөөсөн үймээн самуун, аллага хядлагын талаар ахмад дайчин Б.Цэвэгжавын дурдатгалд: “...Алтай аймгийн Захуй, Зарман, Элст мянган, Гүн тамгаар нутагладаг айлуудад хотоор хоньтой, азаргаар адуутай нэг ч айл үлдсэнгүй. Гол төлөв 50-60 ямаатай, нар сар нэвт туссан гэрийн оронцогтой. Айлуудын гэрийн дотор ямааны арьс, тугалын адасган дэвсгэр, хагархай модон тагшнаас өөр зүйлгүй байв...” гэж өгүүлжээ. Үүнээс үзэхэд тухайн үед Монгол орны баруун, баруун өмнө хязгаарт амьдарч байсан ахмад үеийнхэн эдүгээ хүртэл хасгийн дээрэмчдийн аймшигт дээрэм тонуул, аллагын тухай хорсол заналтайгаар айдас хүрэм, нүдэнд харагдтал, ой ухаанд буутал амнаас ам дамжин ярьсаар иржээ.

Дээрэмчдийн довтолгоонд өртсөн хязгаарын ардууд мал, хөрөнгөтэйгөө уул хаданд нуугдан бүгж байсан ба зарим нь орон нутгаасаа дайжин нүүж байлаа. Үенч, Алтай сумдын ардуудын санаа сэтгэл алдарч “...Биднийг мартсан засаг хэзээ бидний зүгт анхаарал тавих бол. Биднийг дээрэмдэх хүнд хэцүү аюулыг хэзээ арилгах бол. Бид нарт зэвсэг өг, өөрсдөө Шинжаан явж малаа хүчээр булаан авъя...” хэмээн сум, орон нутгийн удирдлагадаа удаа дараа хүсэлт гаргаж байсан нь тэд дээрэмчдийн эсрэг зориглон тэмцэхэд сэтгэл санааны хувьд бэлэн болсон байсныг илтгэж байна. БНМАУ-ын нам, засгийн бодлогыг эсэргүүцэгч этгээдүүд баруун хязгаарын бүс нутагт элдэв төрлийн цуурхал тараах, үймээн самуун гаргах, төрөөс явуулж буй бодлого, үйл ажиллагааг мушгин гуйвуулж байсан байна. Тухайлбал, Булган сумын хувилгаан лам Галсанжамц гэгч “...Шинжаан мужтай нийлэх нь чухал. Монголын Хязгаарын цэрэг нь юу ч биш, тэд цөм алагдсан...” хэмээн цуурхал тарааж, хязгаар нутагт оршин суугчдын санаа сэтгэлийг алдагдуулж байв.


Засгийн газар 1934 оны 9 дүгээр сард “Баруун хилийн байдал”-ыг авч хэлэлцэн Ховдын хязгаарт үүрлэсэн дайсныг Ардын цэргийн ангиуд, Дотоодыг хамгаалах газрын хилийн отряд, заставын нэгдсэн хүчээр устгах шийдвэр гарган, ерөнхий командлагчаар нь Бүх цэргийн жанжин, маршал Г.Дэмидийг томилжээ. Энэ үед Ховдын хязгаар

нутаг Ярант, Хавтаг, Байтаг уулын орчимд 1700 гаруй зэвсэгт дээрэмчид хилээс дотогш байрлаж, зэвсэгт дээрмийн ажиллагаа үргэлжлүүлж байв.

Маршал Г.Дэмидийн удирдлагад Ховдын морьт 4 дүгээр хороо, Хязгаарын цэргийн штабын дарга Жанцангийн Намсрайн удирдсан Ховдын отряд, тусгай хорооны бүлэг, Чоймболын Шагдарсүрэн даргатай, В.А.Судец зөвлөхтэй Р-5 нисэх онгоцны эскадриль болон Ардын сайн дурынхнаас бүрдэж байв.

Ховдын морьт 4 дүгээр хороо, хилийн 6, 7 дугаар заставын хүчтэй хамтарч, Нисэх эскадриль агаараас дэмжлэг үзүүлэн Цагаан болон Чингэл гол дахь дайсныг бут цохиж, мөн Байтаг, Хавтагт үүрлэсэн дайсныг хилчид, Нисэх эскадрилын дэмжлэгтэйгээр бутцохиж, байлдааны ажиллагаанд тавигдсан үүргээ ханган биелүүлсэн байна. Байлдааны ажиллагааны үр дүнд баруун хязгаарт үүрлэсэн хасгийн зэвсэгт бүлэг сарнин бутарч, 1000 шахам дээрэмчдийг устгаж, 40.000 гаруй малыг эргүүлэн авч, дүрвэн гарсан хасаг, торгууд, захчин, урианхай нийт 1500 гаруй өрх айлын 7000 орчим хүн ам эх нутагтаа эргэн ирж амьдран суух болжээ. Энэхүү цэргийн тусгай ажиллагаанд Ховд аймгийн Булган, Үенч, Алтай сумдаас 50 гаруй орон нутгийн ард иргэд хилчидтэй хамтран Байтаг, Хавтагт үүрлэсэн дайсныг устгахад оролцсон байна.

Зураг 2. Байлдааны ажиллагааны зураг.



1934 онд хасгийн дээрэмчдийг МАХЦ тусгай операц зохион байгуулж, бутцохисон хэдий ч хилийн байдал түгшүүртэй хэвээр үлдсэн юм.

Монгол Улсын баруун, баруун өмнөд чиглэлээр Гоминданы хятад, Оспаны зэвсэгт бүлэглэлүүд 1940 оод оны эхэн үеэс улсын хил нэвтрэн хилийн застав, харуул руу довтолж устгах, ард олны мал хөрөнгийг дээрэмдэн, амь насыг нь бүрэлгэх явдал байнга өдүүлэх болсон тул нам, засгаас Хязгаарын цэргийн анги, салбарт туслалцуулахаар нутгийн ардуудыг зэвсэглэн улсын хил хамгаалалтад туслалцуулж эхэлсэн юм.

Маршал Х.Чойбалсан 1944 оны 2 дугаар сард Алагтолгойд Оспантай уулзсаны дараа Ховдын Булган сумын ард Батбаярын Дүгэрийг дуудуулан уулзаж, хилчдэд туслах тусгай үүрэг гүйцэтгэх “Ардын сайн дурын групп”-ийг тусгайлан удирдан зохион байгуулах талаар чиглэл өгсөн байна.

Группийн гишүүд Гоминданы цэргийн бүлэглэлийн байршил, үйл ажиллагааг тагнан турших, амьд хэл

олзлох, хилчидтэй хамтран дээрэмчдэд цохилт өгөх, хүчинд автагдан хилийн цаана нүүж гарсан айлуудыг нутагт нь буцааж авчрах зэрэг чухал даалгаврыг чадварлаг гүйцэтгэж байсан юм.

Ховд аймгийн Булган суманд байгуулагдсан Ардын группээс гадна Баян-Өлгий, Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь аймгийн хил орчмын ард иргэд сайн дураараа нэгдэн элгэн садан эх орноо харийн түрэмгийлэгчдээс өмгөөлөн тэмцсэн байдаг. Дээрх аймгийн хилийн сумдын ард иргэд эх нутгаасаа дүрвэн аж амьдрал нь доройтож, санаа сэтгэл тогтворгүй болж, төөрөлдсөн ардуудыг хэсэг бүлгээр нь хилийн чанадаас Монголд нүүлгэн оруулах ажлыг амжилттай зохион байгуулсан төдийгүй эсрэг талын байдлыг нарийвчлан тагнаж, шаардлагатай мэдээллээр удирдлагыг тогтмол хангаж байв.

Маршал Х.Чойбалсангаас 1944 онд ДЯЯ-нд өгсөн зааврыг үндэслэн тус яамны сайд Дүйнхоржав хил орчмын ард иргэдээс итгэл найдвар бүхий эх оронч, газар орноо сайн мэдддэг,

нутгийн уугуул иргэдийг сонгон авч дараах 8 чиглэлд тусгай ажиллагаа зохион байгуулжээ. Үүнд:

**Ховог сайрын ажиллагаа:**

Группийн дарга: \_\_\_Ховд аймгийн Булган сумын харьяат Б.Дүгэр, Т.Амарзаяа

Гишүүд: Пагваа, Нямдэлэг, Чулуудай нарын 30 хүн

Хугацаа: 1944 оны 4 дүгээр сараас 9 дүгээр сар хүртэл

Гүйцэтгэсэн үүрэг: Дүрвэгсдийн дунд ухуулах хуудас тараасны дүнд Ховог Сайрын торгууд хошууны зарим сумыг бослогод хамруулж, тэдгээрийг мал хөрөнгийн хамт Монгол Улсад нүүдэллэн ирүүлжээ.

**Каваа, Буурчийн ажиллагаа:**

Группийн дарга: Аймгийн дарга Хав

Гишүүд: Баян-Өлгий аймгийн Казак иргэдээс бүрдсэн 120 хүнтэй

Хугацаа: 1944 оны 3 дугаар сараас 7 дугаар сар хүртэл

Гүйцэтгэсэн үүрэг: Цагаан Түнгэ хотыг эзэлж, шоронд хоригдож байсан Казак, урианхайн нэр нөлөө бүхий 30 орчим хүнийг суллажээ. Хятадын цэргээс 65 хүн алагдажээ.

**Мулейхэ хошууны ажиллагаа:**

Группийн дарга: Шинжаан мужийн харьяат Ү.Сагадай

Гишүүд: Ховд аймгийн Үенч сумын харьяат хасаг 20 орчим хүн

Хугацаа: 1944 оны 9 дүгээр сарын 2-ноос 9 дүгээр сарын 23

Гүйцэтгэсэн үүрэг: Шинжааны Мулейхэ хошууны нутаг дэвсгэрт явуулжээ. Группийн гишүүд Хятад цэргийн хүнсний хонь 6000, үхэр 150, адуу 60 толгойг олзлон 3000 хонийг Булган дахь тагнуулын группэд

шилжүүлэн өгч, оногдсон үүргээ нэр төртэй гүйцэтгэжээ.

**Цонж хотын чиглэлд зохиосон ажиллагаа:**

Группийн дарга: Ховд аймгийн Булган сумын харьяат Б.Дүгэр

Гишүүд: Ховдын Булган сумын 60 хүн

Хугацаа: 1944 оны 10 дугаар сарын 25-наас 11 сарын 05

Гүйцэтгэсэн үүрэг: Сантай, Жимсайр тосгоны урианхай 200 гаруй өрхийн 750 орчим хүн амыг мал хөрөнгийн хамт БНМАУ руу дүрвүүлэн нүүлгэжээ.

**Хөх тохойн чиглэлд зохиосон ажиллагаа:**

Группийн дарга: аймгийн намын хорооны дарга Ногой

Гишүүд: Баян-Өлгий аймгийн Хужирт, Дэлүүн, Толбо сумдын 140 казах иргэд

Хугацаа: 1944 оны 5-10 дугаар сар хүртэл

Гүйцэтгэсэн үүрэг: Шар сүм, Хөх тохойн хошуунаас 3000 гаруй хасаг, 110 гаруй урианхай бүгд 3200-аад өрх айлыг өөрийн талдаа оруулжээ.

**Шар тохойн чиглэлд зохиосон ажиллагаа:**

Группийн дарга ахлах дэслэгч Э.Шийлэг

Гишүүд: Ногойн группийн хэсэг ард иргэд

Хугацаа: 1944 оны 11 дүгээр сарын 21

Гүйцэтгэсэн үүрэг: Шар тохойд Хятадын 32 машинтай цэргийн цуваа руу довтолж, дайсны 40 гаруй хүнийг устгаж, манай талаас 2 хүн алагдаж, 5 хүн шархадсан байна.



**Дотор харын чиглэлд  
зохиосон ажиллагаа:**

Группийн дарга ахлах  
дэслэгч Э.Шийлэг, Д.Жамъяан

Гишүүд: Ногойн группийн  
хэсэг ард иргэд

Хугацаа: 1944 оны 9 дүгээр  
сарын 02

Гүйцэтгэсэн үүрэг: Шинжааны  
Мулейхэ хошууны нутагт 25 хоногийн  
хугацаатай Шинжаан мужийн олон  
үндэстэн, ястны эрх чөлөөний төлөөх  
бослого хөдөлгөөнтэй холбоо тогтоох

**Зам бэлх ажиллагаа:**

Группийн дарга:  
С.Рэнцэнхорлоо

Гишүүд: Өмнөговь аймаг дахь  
хилийн отрядын зарим бүрэлдэхүүн

Хугацаа: 1944 он

Гүйцэтгэсэн үүрэг: Өмнөговь  
аймаг дахь хилийн отрядыг  
түшиглүүлэн Анши, Хами чиглэлийн  
төв замыг бүрэн хяналтдаа авсны  
дүнд Гоминданы цэргийн анги,  
салбарын нэмэлт хүчийг Шинжаанд  
нэвтрэх замыг таслан саатуулжээ.

Хилийн сумдын ард иргэдийн  
оролцоотойгоор явагдсан эдгээр  
тусгай ажиллагаанууд нь Шинжаан  
мужийн олон үндэстэн, ястны эрх  
чөлөөний төлөөх бослого  
хөдөлгөөнтэй холбоо тогтоох,  
Гоминьданы Хятадын эсрэг бослого  
гаргуулах, цэргийн зориулалттай  
засмал зам, гүүрийг дэлбэлэх,  
телефон утас таслах, цэргийн  
буудал, баазыг устгах, дээрэмчдийн  
бүлэглэлийн байршил, үйл  
ажиллагааг тагнан турших, амьд хэл  
олзлох, хилчидтэй хамтран  
дээрэмчдэд цохилт өгөх, хүчинд  
автогдан хилийн цаана нүүж гарсан  
айлуудыг нутагт нь буцааж авчрах  
зэрэг чухал даалгавруудыг чадварлаг  
гүйцэтгэж байсан олон арван

“Ардын сайн дурын групп”-ийн  
гишүүдийг тухай бүр нь Төр засгаас  
төрийн одон медалиар шагнаж  
байсан байна.

Улсын Бага хурлын  
тэргүүлэгчдийн 1944 оны 9 дүгээр  
сарын 16-ны 70 дугаар тогтоолоор «...  
Эх орны дархан хил хязгаарыг  
баглан хамгаалж, дайсны аюул  
заналыг цаг тухай бүр няцаан  
устгасан...хэмээж, “Цэргийн гавьяаны  
улаан тугийн одон”-оор Аюушийн  
Намжил Дорнод аймгийн Жаргалант  
сумын харьяат Догсомын  
Дамдинпүрэв, Ховд дахь Гүйцэтгэх  
группийн ажилтан Улаанбаатар  
хотын харьяат ахмад Доржийн  
Лувсанбалдан нарыг, Мөн Улсын  
Бага хурлын тэргүүлэгчдийн 1944  
оны 11-р сарын 14-ий 88-р  
тогтоолоор, «Цусан гавьяаны улаан  
тугийн одон»-оор Ховд аймгийн  
Булган сумын 6-р багийн ард  
Батбаярын Дүгэр, Ховд аймгийн  
Булган сумын ард Агдуугийн Дүгэр,  
мөн аймаг, сумын ард Гашгайн  
Житгээг, «Алтангадас» одонгоор  
Ховд аймгийн Булган сумын 6-р  
багийн ард Төмөрцоггын Амарзаяа,  
мөн сумын 7-р багийн ард Баарайн  
Чулуудай, Ховд аймгийн Булган  
сумын 5-р багийн ард Цагааны  
Пагваа нарыг, «Байлдааны медаль»-  
аар Ховд аймгийн Булган сумын 6-р  
багийн ард Батжаргалын Дүгэр, мөн  
аймаг, сум, багийн ард Шаалуугийн  
Хишигт, мөн аймаг, сум, багийн ард  
Очирын Нямдэлэг, мөн аймаг, сумын  
2-р багийн ард Довжирын Бат, мөн  
аймаг, сум, 6-р багийн ард  
Мужиндайн Түмбээ нарыг сайшаан  
шагнажээ. Баруун, баруун өмнө  
хязгаарын Орон нутгийн ард иргэд  
улсынхаа тусгаар тогтнол, эрх чөлөө,  
нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн

байдлын төлөө амь биеэ үл хайрлан хүчин зүтгэж, байсныг түүхийн шаралсан хуудаснаас харагдаж байна. АИХ-ын Тэргүүлэгчдийн 1968 оны 146-р зарлигаар Тусгай группийн гишүүн, Ховд аймгийн Булган сумын харьяат, ард Баясгалангийн Бадамд “БНМАУ-ын баатар цол” нэхэн олгож, АИХТ-ийн зарлигаар 1984 онд Энхийн Шийлэгт БНМАУ-ын баатар цолыг олгожээ.

### **Дүгнэлт**

1. Баруун хилийн зэвсэгт тулгаралт ба хилийн сумдын ард иргэдийн байлдааны ажиллагаа явагдсан газар орныг хамрах хүрээгээр нь авч үзвэл: Баян-Өлгий аймаг дахь Даянгийн заставаас Өмнөговь аймгийн Замбэлгэхийн застав хүртэл 1200 шахам км урт, улсын хилийн шугамаас Ховд аймгийн Зэрэг сум хүртэл 250 гаруй км өргөн бүс нутаг дэвсгэрт болж өнгөрчээ. Уг 1200 км хилийн шугамын дагуу Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Баянхонгор зэрэг 4 аймгийн 12 сумдын нутаг дэвсгэр багтаж байна.

2. Гоминданы хятад, Оспаны зэвсэгт түрэмгийллийн эсрэг орон нутгийн ард, иргэд өрх гэр бүл, айл хотлоороо зохион байгуулалтайгаар группт орж Хязгаарын цэрэгтэй хамтран тэмцсэний үр дүнд Баян-Өлгий аймаг, Ховд аймгийн Булган, Үенч, Алтай сум, Говь-Алтай аймгийн Алтай, Бугат, Эрдэнэ, Цогт сум, Баянхонгор аймгийн Шинэжинст, Баян-Өндөр зэрэг хилийн сумдын газар нутгийг бүрэн хамгаалж, чадсаны үр дүнд Монгол Улсын өнөөгийн газар нутгийг бүрэн авч үлдсэн байна.

3. Баруун хязгаарын ард иргэдийн Эх орон, элгэн саднаа өмгөөлөн хамгаалсан тэмцлийн үр

дүнд Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь аймгийн гадаадад дүрвэн гарсан 4000 гаруй өрх айлын 13.000 гаруй иргэд, 48149 мал, хөрөнгийн хамт нүүдэллэн ирж, эх нутагтаа амьдрах нөхцөл бүрдсэн.

4. Монгол орны Зүүн хязгаарт Японы түрэмгийлэл идэвхжиж 1939 оны Халхын голын дайн, 1945 оны чөлөөлөх дайнтай зэрэгцэн улс орны аюулгүй байдалд заналхийлж байсан хүнд үед Төр засгаас Баруун хязгаар, Шинжаан мужид зохион байгуулсан эдгээр томоохон арга хэмжээний үр дүн нь баруун хязгаарын аюулгүй байдлыг хангаж, Гоминданы хятадын цэргийн эрхтнүүдээс баруун хил рүү довтлох бодлого, хүчийг сулруулах, Монголын баруун хилийг цэрэг-тагнуулын хүчээр өнгөлзөн эзлэх гэсэн санаархлыг таслан зогсоосон нь онцлог юм.

5. Баруун хязгаарт олон жил үргэлжилсэн Гоминданы хятадын зэвсэгт өдөөн хатгалга, Оспаны дээрэмчдийн эсрэг олон зуун Ардын сайн дурын группийн гишүүд, хил орчмын ард иргэд хүнд хэцүү бэрх нөхцөлд амь насаа үл хайрлан ил, далд аргаар тэмцсэний үр дүнд баруун хил хязгаарын байдал тогтворжиход чухал хувь нэмэр оруулсан гэж үзэх бүрэн үндэслэлтэй. Монгол Улсын тусгаар тогтнол бүрэн эрхт байдлыг Олон улсад баталгаажуулахад түлхэц болсноороо түүхэн ач холбогдолтой юм.

6. Баруун хязгаарыг аюулгүй байдлыг хангахад орон нутгийн засаг захиргаа, ард иргэдийг өргөнөөр дайчлан оролцуулсан нь өнөөгийн Улсын хил хамгаалалтад туслах хүчний үндсэн суурийг тавьж өгсөн. Өнөөгийн байдлаар Баян-Өлгий,



Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь аймгийн Хил хамгаалалтад туслах хүчний 844 гаруй гишүүд мал маллах, газар тариалан эрхлэх өвөлжих, хаваржих байрлалаараа улсын хил хамгаалалтад оролцож байна. Улсын хил хамгаалалтад ард, иргэдийг оролцуулах ажиллагааг журмаар зохицуулж байсныг Монгол Улсын Их хурлаас 2016 онд батлагдсан хилийн тухай хуулийн 6 дугаар бүлэгт Улсын хилийн аюулгүй байдлыг хангахад төрийн болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтны эрх, үүрэг, 7 дугаар бүлэгт Улсын хил хамгаалалтад

туслах хүчний оролцоо, иргэний эрх, үүрэг гэсэн тусгай бүлэг болгож, эрх зүйн үндсийг бүрдүүлсэн байна.

### **Санал**

Цаашид 1940-өөд онд Баруун хязгаар, Шинжаан мужид Гоминданы хятад, Оспаны дээрэмчдийн эсрэг Монгол Улсын төрөөс газар нутаг, хилийн халдашгүй дархан байдлын төлөө авч явуулсан арга хэмжээ, түүний үр дүн, сургамжийн талаарх судалгааг хийж, ард иргэд, хүүхэд залууст сурталчлах, эх оронч хүмүүжил олгох нэг сэдэв болгох нь зүйтэй болно.